



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 21 өдөр

Дугаар A/189

Ховд

Орон тооны бус зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 282 дугаар тогтоолоор батлагдсан “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөл”-ийн 2017 оны 3 дугаар хурлын шийдвэрийн хэрэгжилтийг хангуулж ажиллах зорилгоор гаргасан Барилга хот байгуулалтын сайдын 2017 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 03 дугаар албан даалгаврыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Шадар сайдын 2017 оны 78 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох, паспортжуулах журам”-ын дагуу Ховд аймгийн нутаг дэвсгэр дэх нийт барилга байгууламжийг паспортжуулах ажлыг зохион байгуулах Орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Паспортжуулах зөвлөлийн хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг батлуулан хуулийн хугацаанд мэргэжлийн өндөр түвшинд хийж гүйцэтгэхийг зөвлөлийн орлогч аймгийн Ерөнхий архитекторч /З.Өмиртай/-д үүрэг болгосугай.


3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч бөгөөд зөвлөлийн дарга /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б. ДҮГЭРЖАВ



Аймгийн Засаг даргын 2019 оны
03 дугаар сарын 21-ний өдрийн
А/189 дүгээр захирамжийн хавсралт



ОРОН ТООНЫ БУС ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Зөвлөлийн дарга: Т.Жаргалсайхан -Аймгийн Засаг даргын орлогч
- Орлогч дарга: З.Өмиртай -Аймгийн Ерөнхий архитекторч бөгөөд
Газрын харилцаа, барилга хот
байгуулалтын газрын Барилга хот
байгуулалтын хэлтсийн дарга
- Гишүүд:
- С.Загдсүрэн -Одон орон геофизикийн хүрээлэнгийн
Ховд салбарын эрхлэгч
 - Э.Нямдорж -Мэргэшсэн инженер
 - Д.Нямтулга -Мэргэшсэн инженер
 - П.Буянжаргал -Мэргэшсэн инженер

Нарийн бичгийн дарга: Б.Түмэндэмбэрэл -Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого,
төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

-оОо-